ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ДАА-2022/11/НА-СА-ТШ3


Цахим хуудас:
www.audit.mn

Дархан-Уул аймаг

2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**
Утас: **7037-3089**
Цахим хаяг: m**unkhbayarsh@audit.gov.mn**
Ахлах аудитор: **С.Батцэцэг**
Утас: **7037-3089**
Цахим хаяг: battsetsegs**@audit.gov.mn**
Аудитор: Ч**.Цэрэннадмид**
Утас: **9511-2689**
Цахим хаяг: tsesb.audit**@gmail.com**


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт....2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....3
3. Аудитын тайлан....12
3.1 Ерөнхий зүйл ....12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт....12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....12
3.4 Материаллаг байдал....12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга....13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ....14
3.8 Аудитын гол асуудал....14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....15

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БСУГ | Боловсрол соёл, урлагийн газар |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
45050 Дархан-Уул аймаг
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

2022.02.25 № 206
танай ______ -ны № ______ -т

ДАРХАН СУМЫН 1 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
В.ОТГОНХҮҮ ТАНАА

01 ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ /Ш.МӨНХБАЯР/

009020711

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **15,793,991.50** | **12,325,101.04** |
| **31** | **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө** | - | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **15,793,991.50** | **12,325,101.04** |
| **351** | Түүхий эд материал | **8,060,891.50** | **6,969,708.44** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 4,749,524.00 | 4,154,459.00 |
| 35130 | Эм боох материал | 3,311,367.50 | 2,815,249.44 |
| 354 | **Хангамжийн материал** | **7,733,100.00** | **5,355,392.60** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 869,720.00 | 327,370.60 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,548,900.00 | 1,851,400.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 700,000.00 | 274,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 3,614,480.00 | 2,902,622.00 |
| 36 | **НӨӨЦИЙН БАРАА** | | |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,350,533,000.21** | **1,306,546,111.94** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,350,533,000.21** | **1,306,546,111.94** |
| **392** | **Биет хөрөнгийн дүн** | **1,139,120,850.29** | **1,095,415,037.06** |
| 39201 | Барилга байгууламж | 1,128,018,970.00 | 1,128,018,970.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (61,433,681.04) | (92,150,521.56) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж | 26,433,000.00 | 26,433,000.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (6,202,095.82) | (12,632,037.73) |
| 39207 | Тавилга, эд хогшил | 55,053,662.57 | 57,912,281.57 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (21,868,305.99) | (31,138,078.47) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 20,152,518.32 | 23,470,518.32 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (3,226,997.75) | (6,692,875.07) |
| 39217 | Ном | 2,193,780.00 | 2,193,780.00 |
| **393** | **Биет бус хөрөнгийн дүн** | **211,412,149.92** | **211,131,074.88** |
| 39301 | Программ хангамж | 1,124,300.00 | 1,124,300.00 |
| 39302 | Хасагдуулга | (562,150.08) | (843,225.12) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 210,850,000.00 | 210,850,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,366,326,991.71** | **1,318,871,212.98** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | - | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,366,326,991.71** | **1,318,871,212.98** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,366,326,991.71 | 1,318,871,212.98 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал | 558,407,638.00 | 558,407,638.00 |
| 51101 | Өмч: -төрийн | | |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | **(346,450,952.09)** | **(393,906,730.82)** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (342,823,959.85) | (346,450,952.09) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (3,626,992.24) | (47,455,778.73) |
| 51300 | Дахин үнэлгээний зөрүү | 1,154,370,305.80 | 1,154,370,305.80 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН** | **1,366,326,991.71** | **1,318,871,212.98** |

ДУГААР 01

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **393,491,022.51** | **340,114,309.20** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **36,396,122.51** | **3,131,419.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | **36,396,122.51** | **3,131,419.00** |
| 120002 | Хүүгийн орлого | | |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | **36,396,122.51** | **3,236,419.00** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | 547,200.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 36,396,122.51 | 2,584,219.00 |
| 13 | **ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **357,094,900.00** | **336,877,890.20** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **344,749,200.00** | **316,253,500.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүдгээс санхүүжих | 344,749,200.00 | 316,253,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **105,000.00** | **231,290.20** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө | | 126,290.20 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 105,000.00 | 105,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **12,240,700.00** | **20,498,100.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 12,240,700.00 | 20,498,100.00 |
| **2** | **Үйл ажиллагааны зардал** | **397,058,014.75** | **387,022,887.93** |
| **21** | **Урсгал зардал** | **397,058,014.75** | **387,022,887.93** |
| **210** | **Бараа, үйлчилгээний зардал** | **384,577,545.22** | **376,938,660.90** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал** | **264,677,265.00** | **259,563,474.00** |
| 210101 | Үндсэн цалин | 191,597,990.00 | 184,353,240.00 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 55,683,575.00 | 53,269,209.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 350,700.00 | 2,652,600.00 |
| 210104 | Урамшуулал | 17,045,000.00 | 19,288,425.00 |
| **2102** | **Нийгмийн даатгалын шимтгэл** | **33,510,765.47** | **34,138,270.50** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын | 23,673,412.47 | 24,183,619.69 |
| 210202 | тэтгэмжийн даатгалын | 2,558,766.00 | 2,621,524.78 |
| 210203 | ҮОМШӨ-ий даатгалын | 2,123,131.00 | 2,214,957.16 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын | 462,303.00 | 465,288.25 |
| 210205 | ЭМ-ийн даатгалын | 4,693,153.00 | 4,652,880.62 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **9,040,700.00** | **11,454,664.47** |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 3,279,641.80 | 2,498,558.66 |
| 210302 | Түлш,халаалтын зардал | 4,787,895.39 | 6,435,061.79 |
| 210303 | Цэвэр бохир усны зардал | 973,162.81 | 2,521,044.02 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **10,103,643.50** | **3,188,414.40** |
| 210401 | Бичиг хэргийн зардал | 1,266,550.00 | 93,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн зардал | 580,000.00 | 580,000.00 |
| 210405 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 2,005,737.50 | 189,800.00 |
| 210406 | Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал | | 933,049.40 |

| | | | |
|---|---|---|---|
| 210408 | Бараа материал акталсны зардал | 6,251,356.00 | 1,392,565.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **22,723,046.50** | **14,342,730.26** |
| 210502 | Хоол, хүнс | 21,736,750.50 | 13,625,422.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл | 986,296.00 | 717,308.26 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,560,000.00** | **3,157,500.00** |
| 210604 | Урсгал засварын зардал | 2,560,000.00 | 3,157,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс** | **662,000.00** | **580,800.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр | 237,000.00 | |
| 210802 | Аудит баталгаажуулалтын зардал | 425,000.00 | 580,800.00 |
| **2109** | **Бараа, үйлчилгээний бусад зардал** | **41,300,124.75** | **50,512,807.27** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 200,000.00 | 349,300.00 |
| **213** | **Урсгал шилжүүлэг** | **12,480,469.53** | **10,084,227.03** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **-** | **-** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **-** | **4,043,435.53** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 4,043,435.53 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **12,480,469.53** | **6,040,791.50** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 12,480,469.53 | 6,040,791.50 |
| **3** | **Үйл ажиллагааны үр дүн** | **(3,566,992.24)** | **(46,908,578.73)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **60,000.00** | **547,200.00** |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал- Үндсэн хөрөнгө | 60,000.00 | 547,200.00 |
| **4** | **Үйл ажиллагааны бус үр дүн** | (60,000.00) | (547,200.00) |
| **5** | **Үйл ажиллагааны нийт үр дүн** | **(3,626,992.24)** | **(47,455,778.73)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /Төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны үр дүн |
|---|---|---|---|---|
| A | 1 | 2 | 3 | 4 |
| **2019 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл** | 558,407,638.00 | 1,154,370,305.80 | (342,823,959.85) | 1,369,953,983.95 |
| НББ-ийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | - |
| ҮХ-ийн өсөлт, бууралт | | | | - |
| ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | - |
| Тайлант үеийн үр дүн | | | (3,626,992.24) | (3,626,992.24) |
| **2020 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл** | 558,407,638.00 | 1,154,370,305.80 | (346,450,952.09) | 1,366,326,991.71 |
| НББ-ийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| ҮХ-ийн өсөлт, бууралт | | | | - |
| ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт | | | | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | - |
| Тайлант үеийн үр дүн | | | (47,455,778.73) | (47,455,778.73) |
| **2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл** | 558,407,638.00 | 1,154,370,305.80 | (393,906,730.82) | 1,318,871,212.98 |

ДУГААР 01

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **356,989,900.00** | **336,982,890.20** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | - | - |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | - |
| 120009 | Бусад орлого | | - |
| **120004** | **Төсөвт байгууллагын өөрийн орлого** | - | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | | |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | - | - |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | | |
| **13** | **ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **356,989,900.00** | **336,982,890.20** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **344,749,200.00** | **316,253,500.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 344,749,200.00 | 316,253,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | **231,290.20** |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө | | 126,290.20 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 105,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **12,240,700.00** | **20,498,100.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 12,240,700.00 | 20,498,100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **354,440,000.00** | **333,390,490.20** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **354,440,000.00** | **333,390,490.20** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **341,959,530.47** | **323,306,263.17** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал** | **264,677,265.00** | **259,563,474.00** |
| 210101 | Үндсэн цалин | 191,597,990.00 | 184,353,240.00 |
| 210102 | Нэмэгдэл | 55,683,575.00 | 53,269,209.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 350,700.00 | 2,652,600.00 |
| 210104 | Урамшуулал | 17,045,000.00 | 19,288,425.00 |
| **2102** | **Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **33,510,765.47** | **34,138,270.50** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын | 23,673,412.47 | 24,183,619.69 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын | 2,558,766.00 | 2,621,524.78 |
| 210203 | ҮОМШӨ-ий даатгалын | 2,123,131.00 | 2,214,957.16 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын | 462,303.00 | 465,288.25 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын | 4,693,153.00 | 4,652,880.62 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **9,040,700.00** | **11,454,664.47** |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 3,279,641.80 | 2,498,558.66 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 4,787,895.39 | 6,435,061.79 |
| 210303 | Цэвэр бохир усны зардал | 973,162.81 | 2,521,044.02 |
| **2104** | **Хангамж, бараа материал** | **6,400,800.00** | **1,241,090.20** |
| 210401 | Бичиг хэргийн зардал | 120,000.00 | 155,000.00 |
| 210403 | Шуудан холбооны зардал, мэдээлэл тех-гийн үйлчилгээ | 580,000.00 | 580,000.00 |

ЦЭЭБ-АУДИТ ХХК ДУГААР 01

| | | | |
|---|---|---|---|
| 210404 | Ном | | 47,700.00 |
| 210405 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 3,639,600.00 | 316,090.20 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,061,200.00 | 142,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **24,208,000.00** | **13,008,464.00** |
| 210501 | Эм | 2,629,200.00 | 94,900.00 |
| 210502 | Хоол,хүнс | 21,578,800.00 | 12,913,564.00 |
| **2106** | **Эд хогшил урсгал засвар** | **3,200,000.00** | **2,731,500.00** |
| 210604 | Урсгал засвар | 3,200,000.00 | 2,731,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **-** | **-** |
| 210702 | Дотоодын томилолт | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж** | **722,000.00** | **580,800.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил , үйлчилгээний төлбөр, хураамж | 297,000.00 | |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 425,000.00 | 580,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **200,000.00** | **588,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 200,000.00 | 588,000.00 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **12,480,469.53** | **10,084,227.03** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **-** | **-** |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **-** | **-** |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж | | |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт , шилжүүлэг** | **-** | **-** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **-** | **4,043,435.53** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 4,043,435.53 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэлт** | **12,480,469.53** | **6,040,791.50** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 12,480,469.53 | 6,040,791.50 |
| **3** | **Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **2,549,900.00** | **3,592,400.00** |
| **5** | **Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн** | **2,549,900.00** | **3,592,400.00** |
| **22** | **Хөрөнгийн зардал** | **2,549,900.00** | **3,592,400.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **2,549,900.00** | **3,592,400.00** |
| | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | |
| 222001 | Тоног төхөөрөмж | | |
| 223001 | Бусад хөрөнгө | 2,549,900.00 | 3,592,400.00 |
| **6** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **(2,549,900.00)** | **(3,592,400.00)** |
| **7** | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 145004 | Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх | | |
| 8 | **Нийт цэвэр мөнгөн гүйлгээ** | **-** | **-** |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

ҮЭСБ-АУДИТ ХХК ДУГААР 01

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 336,751,600.00 | 326,667,372.97 | 10,084,227.03 | 97.0 |
| 21 | Урсгал зардлын дүн | 336,751,600.00 | 326,667,372.97 | 10,084,227.03 | 97.0 |
| 210 | Бараа үйлчилгээний зардал | 336,751,600.00 | 326,667,372.97 | 10,084,227.03 | 97.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 261,880,600.00 | 259,563,474.00 | 2,286,651.00 | 99.1 |
| 210101 | Үндсэн цалин | 191,461,700.00 | 184,353,240.00 | 7,108,460.00 | 96.3 |
| 210102 | Нэмэгдэл | 50,600,000.00 | 53,269,209.00 | (2,669,209.00) | 105.3 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 500,000.00 | 2,652,600.00 | (2,152,600.00) | 530.5 |
| 210104 | Урамшуулал | 19,318,900.00 | 19,288,425.00 | 30,475.00 | 99.8 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 34,759,300.00 | 34,138,270.50 | 621,029.50 | 98.2 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,193,200.00 | 24,183,619.69 | 9,580.31 | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,641,500.00 | 2,621,524.78 | 19,975.22 | 99.2 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,113,200.00 | 2,214,957.16 | (101,757.16) | 104.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 528,300.00 | 465,288.25 | 63,011.75 | 88.1 |
| 210205 | ЭМД-ын хураамж+В21 | 5,283,100.00 | 4,652,880.62 | 630,219.38 | 88.1 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 15,498,100.00 | 11,454,664.47 | 4,043,435.53 | 73.9 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 3,922,700.00 | 2,498,558.66 | 1,424,141.34 | 63.7 |
| 210302 | Түлш,халаалтын зардал | 8,160,800.00 | 6,435,061.79 | 1,725,738.21 | 78.9 |
| 210303 | Цэвэр бохир усны зардал | 3,414,600.00 | 2,521,044.02 | 893,555.98 | 73.8 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,079,800.00 | 1,079,800.00 | - | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 120,000.00 | 120,000.00 | - | 100.0 |
| 210403 | Шуудан холбоо | 580,000.00 | 580,000.00 | - | 100.0 |
| 210404 | Ном | 47,700.00 | 47,700.00 | - | 100.0 |
| 210405 | Хог хаягдал | 189,800.00 | 189,800.00 | - | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл | 142,300.00 | 142,300.00 | - | 100.0 |
| 2105 | Нормативт зардал | 16,585,500.00 | 13,482,864.00 | 3,102,636.00 | 81.3 |
| 210501 | Эм | 94,900.00 | 94,900.00 | - | 100.0 |
| 210502 | Хоол хүнс | 16,016,200.00 | 12,913,564.00 | 3,102,636.00 | 80.6 |
| 210503 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 474,400.00 | 474,400.00 | - | 100.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,000,000.00 | 5,000,000.00 | - | 100.0 |
| 210601 | Багаж хэрэгсэл | | | - | |
| 210604 | Урсгал засвар | 5,000,000.00 | 5,000,000.00 | - | 100.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр | 580,800.00 | 580,800.00 | - | 100.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 580,800.00 | 580,800.00 | - | 100.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,367,500.00 | 1,367,500.00 | - | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 567,500.00 | 567,500.00 | - | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 800,000.00 | 800,000.00 | - | 100.0 |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 336,751,600.00 | 326,667,372.97 | 10,084,227.03 | 97.0 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 316,253,500.00 | 310,212,708.50 | 6,040,791.50 | 98.1 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | | | - | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 316,253,500.00 | 310,212,708.50 | 6,040,791.50 | 98.1 |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 20,498,100.00 | 16,454,664.47 | 4,043,435.53 | 80.27 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 20,498,100.00 | 16,454,664.47 | 4,043,435.53 | 80.27 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | - | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | | - | |
| 001 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | | - | |
| 002 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| 003 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 25.00 | 25.00 | - | 100.0 |
| | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| | Гүйцэтгэх ажилтан | 19.00 | 19.00 | - | 100.0 |
| | Үйлчлэх ажилтан | 5.00 | 5.00 | - | 100.0 |
| 010 | СУРАЛЦАГЧДЫН ТОО /ЖИЛИЙН ДУНДЖААР/ | 189.00 | 114.00 | 75.00 | 60.3 |
| 015 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 189.00 | 114.00 | 75.00 | 60.3 |
| 024 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 25.00 | 25.00 | - | 100.0 |
| 028 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч /ТҮБД/ | 15.00 | 15.00 | - | 100.0 |
| 033 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч | 10.00 | 10.00 | - | 100.0 |

ТӨСӨВ-АУДИТ ХХК
ДУГААР 01

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Төгрөгөөр/

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| 2 | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | | 231,290.20 | (231,290.20) |
| 21 | Урсгал зардал | | 231,290.20 | (231,290.20) |
| 210 | Бараа ажил үйлчилгээний зардал | | 231,290.20 | (231,290.20) |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 161,290.20 | (161,290.20) |
| 210401 | Бичиг хэрэг | | 35,000.00 | (35,000.00) |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгдийн устгал, ариутгал | - | 126,290.20 | (126,290.20) |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 70,000.00 | (70,000.00) |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 70,000.00 | (70,000.00) |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | 255,000.00 | (255,000.00) |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн тайлан | | 231,290.20 | (231,290.20) |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 126,290.20 | (126,290.20) |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 105,000.00 | (105,000.00) |

ҮЭСБ-АУДИТ ХХК ДУГААР 01

## Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 1 дүгээр цэцэрлэгийн /цаашид 1 дүгээр цэцэрлэг гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "ЦЭСБ-Аудит" ХХК-ийн захирал аудитор Ч.Цэрэннадмид, аудитор Э.Эрдэнэбат нар гүйцэтгэж, хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, газрын дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

1 дүгээр цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймгийн "ЦЭСБ-Аудит" ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

1 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж болон орон тоо байхгүй.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

1 дүгээр цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 397,058.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,970.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,779.4 мянган төгрөгөөр тогтоосон. Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

ЦЭСБ-АУДИТ ХХК
ДУГААР 01

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 47,455.8 мянган төгрөгөөр буюу 3,4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс, бараа материалын данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 15,794.0 | 12,325.1 | (3,468.9) |
| Үндсэн хөрөнгө | 1,443,826.2 | 1,450,002.8 | 6,176.6 |
| Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл | (93,293.2) | (143,456.7) | (50,163.5) |
| **Нийт хөрөнгө** | **1,366,327.0** | **1,318,871.2** | **(47,455.8)** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо | 1,366,327.0 | 1,318,871.2 | (47,455.8) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,366,327.0** | **1,318,871.2** | **(47,455.8)** |

Бараа материал дансны үлдэгдэл 3,468.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 16,889.9 мянган төгрөгийн материал худалдан авсан, хандиваар 547,2 мянган төгрөгийн аж ахуйн материал хүлээн авч, 20,906.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны хувьд 6,176.6 мянган төгрөгөөр өссөн нь 1,274.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 2,318.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө худалдан авч, 1,584.2 мянган төгрөгийн тавилга эд хогшил хандиваар хүлээн авч байна.

Тайлант онд 50,163.5 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,318,871.2 мянган төгрөг болж 47,455.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 53,376.7 мянган төгрөгөөр буюу 13,5 хувиар буурахад тусламж, санхүүжилтийн орлого 28,495.7 мянган төгрөг, татварын бус орлого 33,159.7 мянган төгрөгөөр тус тус буурч, урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ 8,257.4 мянган төгрөг, нэмэлт санхүүжилт 21,3 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Урсгал зардал өмнөх оноос 10,035.1 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, НДШ-ийн зардал 4,486.3 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 6,915.2 мянган төгрөг, норматив зардал 8,380.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс 81,2 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 2,396.2 мянган төгрөгөөр тус тус буурч, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 2,413.9 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын 597,5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 9,212.7 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

ДУГААР 01

Тус цэцэрлэгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 539,017.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсвийн төслийг өмнөх оны батлагдсан төсвөөс 222,763.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөж төсвийн захирагчид хүргүүлсэн ч 202,265.5 мянган төгрөгөөр бууруулж, 336,751.6 мянган төгрөгөөр баталжээ. Тухайлбал: Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллыг 64,780.2 мянга, норматив зардал 83,748.3 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 47,564.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталсан ба тайлант онд гүйцэтгэлээр цалин 2,938.1 мянган төгрөг, норматив зардал 3,102.6 мянган төгрөг, түлш халаалтын зардал 4,043.4 мянган төгрөгөөр тус тус батлагдсан төсвөөс зарцуулагдаагүй үлдсэн байна. Үүнээс харахад төсвийн төслийг үндэслэлтэй төлөвлөөгүй байна гэж хэлэхээр байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,428,502.9 мянган төгрөгийн төсөв баталсныг бүрэн санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Зардлыг санхүүжүүлэхээр 336,751.6 мянган төгрөгийн төсөв баталсныг тусгай зориулалтын шилжүүлгээс 316,253.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 20,498.1 мянган төгрөг санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 316,253.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 20,498.1 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 326,667.4 мянган төгрөг зарцуулж, 10,084.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 326,667.4 мянган төгрөг буюу 97.01 хувьтай байна. Цалин хөлс, нэмэгдэл урамшил 2,938.1 мянган төгрөг, тогтмол зардал 4,043.4 мянган төгрөг, норматив зардал 3,102.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар БСУГ-аас 126,3 мянган төгрөг, тендерийн орлого 105,0 мянган төгрөг нийт 231.3 мянган төгрөгийн санхүүжилт орж ирснийг зориулалтын дагуу зарцуулжээ.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

## 3.8 Аудитын гол асуудал

1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

## 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 152 мэдээллээс хугацаанд нь 150 мэдээллийг бүрэн оруулсан, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар 1,523.2 мянган төгрөгийн 1 албан шаардлагын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 16 тоот албан бичгээр ирүүлсэн ба тайлагналын дараах үе шатанд дахин хянахад хэрэгжилт 100 хувьтай байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

4. Илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2022.02.24

ҮЭСБ-АУДИТ ХХК
ДУГААР 01